



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 04 сарын 05 өдөр

Дугаар А/156

Мөрөн сум

Төсөвт зохицуулалт хийх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8, 14 дүгээр зүйлийн 4.1, 4.1.20, 42 дугаар зүйлийн 42.2.1а, 65 дугаар зүйлийн 65.1.7, Засгийн газрын 2024 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн 62 дугаар тогтоол, Сангийн сайдын 2018 оны 134 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улс болон аймгийн хэмжээнд өвөлжилт, хаваржилтын нөхцөл байдал эрс хүндэрч өндөржүүлсэн бэлэн байдал зарласан, хэд хэдэн сум зудын эрсдэлийн “их”, “дунд” түвшинд хүрсэн, өвс тэжээлийн нөөц дуусч нэмж бүрдүүлсэн цасанд хаагдсан зам давааг нээхэд нэмэлт зардал их гарсан зэрэг асуудлаас үүдэлтэй өглөг үүссэнийг барагдуулах шаардлагатай байгааг харгалзан Тосонцэнгэл сумын “Орон нутгийн нөөц” хөрөнгийн зардлыг 2023 оны давсан орлого, дансны үлдэгдлээс 20,000,000 (Хорин сая) төгрөгийг нэмэгдүүлэн зохицуулалт хийж баталсугай.

2. Төсвийн зохицуулалтыг хийж, зарлагын сарын хуваарьт өөрчлөлтийг тусгаж батлуулан, мөрдөж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Г.Базар)-д зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (М.Хуягбаатар)-д даалгасугай.

ДАРГА

П.ЛХАГВАЖАВ

